

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

20 17 оны 04-р сарын 18-ны өдөр

№ 12

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль, тогтоомжуудыг үндэслэн нэг талаас төрийн байгууллагыг төлөөлж сумын Засаг даргын орлогч О.Мунтай нөгөө талаас А.Дархан төлөөлж Б.Наранбат нар дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ 1 жилийн хугацаатай байгуулав.

Нэг. Ерөнхий нөхцөл

1.1. Энэхүү гэрээ нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлж, сум орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд тэдгээрийн оролцоог хангах, хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар хураамжийг цаг хугацаанд нь бүрэн барагдуулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаад, дотоод тохижилт, өнгө үзэмжийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, улс, аймаг, төсөл, хөтөлбөр, хувийн хөрөнгө оруулалтаар буй болсон үйлдвэр, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг тогтмолжуулах, шинээр тогтвортой ажлын байр бий болгох, ажиллагсадын нийгэм, ахуй хангамжийг сайжруулах, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлчилгээгээр сумын хэрэгцээг хангаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг статистик мэдээнд бүрэн хамруулахад оршино.

1.2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн нөхцөлд 2 тал харилцан тохиролцож өөрчилж болно.

Хоёр. Сумын ЗДТГ-ын хүлээх үүрэг

2.1. Аймаг, сум орон нутгийн хөгжлийн бодлогод тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.2. Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогыг тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.3. Гадаад, дотоод түншлэлийг өргөжүүлж суманд үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлж ажлын байр олноор бий болгоход дэмжлэг үзүүлж хөнгөлөлттэй зээлд хамруулах ажлыг зохион байгуулна.

2.4. Шаардлагатай мэдээ, мэдээлэлээр үйлчилж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ.

2.5. Сумын бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх, зах зээлд нэвтрүүлэхэд хамтран ажиллаж дэмжлэг үзүүлнэ.

Гурав.Аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг

3.1.Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг улирал бүр хуулийн хугацаанд гаргаж
.....төрлийн татварт.....төгрөг.....төгрөгийн
.....хураамжийг хугацаанд нь төлнө.

3.2.Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг статистик мэдээнд сар бүр бүрэн хамруулна.

3.3.Хэрэглэгчээ дээдэлж, үйлчилгээний ая тухтай орчинг бүрдүүлж, эелдэг найрсаг харилцааг эрхэмлэж, эрүүл ахуй, чанар стандартын шаардлага хангасан олон нэр төрлийн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

3.4. Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх

3.5. Галын аюулгүй байдлыг хангаж ажиллах

3.6. Сумын биеийн тамир спортын арга хэмжээг санхүүжүүлж дэмжин ажиллах

3.7.Сум болон байгууллагынхаа гадаад дотоод тохижилт өнгө үзэмжийг сайжруулах ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор ямар хөрөнгө оруулалтын ажлуудыг хийх талаар

Төсвөрсүрэгч Цэц. Хурталжы Ойроовч Барид
Сумын Талын 408-ын гадна авто машин 2020-аар
талбайг тохижуулах

Байг. цагцагдорон тохижилтанд оролцох

3.8.Сум орон нутгаас зохион байгуулсан олон нийтийн ажил, уралдаан тэмцээн, баяр ёслол хүмүүнлэгийн тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд тасралтгүй оролцоно.

3.9.Ажилласагсадын ажлын байрны тогтвортой байдлыг хангаж, сумын иргэдээс хүнийг ажлын байраар хангана. Шинээражлын байр бий болгоно.

3.10.Ажиллагсадын мэдлэг чадварыг дээшлүүлэхсургалтуудад хүнийг хамруулна. Ажилчдын нийгмийн хангамжийг сайжруулахадажлуудыг хэрэгжүүлнэ.

3.11.Аймаг, сумын сум хөгжүүлэх сан, ЖДҮД сангаас авсан зээлийг зориулалтын дагуу ашиглаж, эргэн төлөгдөх хуваарийн дагуу цаг хугацаанд нь төлбөрийг төлнө.

3.12.Бусад: 1.

2.

3.

Дөрөв. Гэрээний хариуцлага

4.1.Нийгмийн хариуцлагын гэрээг дүгнэх журмын дагуу гэрээг жилийн эцэст дүгнэж, гэрээний биелэлтээр салбар бүрийн шилдэгүүдийг тодруулж шагнаж урамшуулна.

4.2.Гэрээний хариуцлагыг хоёр тал хуулийн дагуу хүлээх ба гэрээнд шууд заагаагүй асуудлыг Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудыг дагуу зохицуулна.

4.3.Энэхүү гэрээний биелэлттэй холбогдсон маргаантай асуудлыг хэлэлцээр зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд харилцан зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд гомдолтой тал нь шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

4.4.Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба гэрээнд гар бичмэлээр тэмдэглэгээнд өөрчлөлт хийж, гэрээний эх хувийг зассан тохиолдолд тэрхүү бичлэгийг хүчинтэйд тооцохгүй. /Гэрээг 3% үйлдэв/

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

Төрийн байгууллагыг төлөөлж :

Засаг даргын орлогч

Ц.Мун
Утас 99479963
70245906

Авгад Хайрхан Тогт төлөөлж,

Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн

Замрал а/а Б.Наранбаат
Утас 70245906